



IX/2022


Тархаасан: 2022 оны 10 дугаар сарын 14



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.2 хувиар буурлаа

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 9 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 13.8 хувь, өмнөх оны эцсээс 9.5 хувиар өсөж, өмнөх сараас 0.2 хувиар буурсан байна.

ЗУРАГ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 17.1 хувь (мах, махан бүтээгдэхүүн 2.2 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 25.9 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 7.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 17.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 12.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 20.3 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 9.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 9 дүгээр сард өмнөх оны эцсээс 9.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 8.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 5.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 13.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 13.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 15.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 9 дүгээр сард өмнөх сараас 0.2 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 0.4 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2022 оны 9 дүгээр сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2022 IX	2022 IX	2022 IX
		2021 IX	2021 XII	2022 VIII
Ерөнхий индекс	100.0	113.8	109.5	99.8
Хүнсний бараа, ундаа, ус	25.1	117.1	108.8	97.8
Согтууруулах ундаа, тамхи	1.2	107.9	105.5	100.4
Хувцас, бөс бараа, гутал	12.3	117.7	113.2	101.1
Орон сууц, ус, цахилгаан, түлш	10.3	112.0	113.1	100.5
Гэр ахуйн тавилга, бараа	5.4	115.5	111.1	101.0
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	7.3	120.3	115.9	100.8
Тээвэр	16.3	109.3	105.1	99.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	5.9	101.6	101.3	100.3
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	1.9	108.9	107.4	101.2
Боловсролын үйлчилгээ	5.2	106.7	106.7	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.9	117.5	112.5	101.2
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	0.5	103.7	103.7	100.0
Бусад бараа, үйлчилгээ	5.7	118.3	113.6	101.6

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 9 дүгээр сард 10.2 хувь гарсан бол 2022 оны 9 дүгээр сард 13.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.6 нэгж хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 2. ИНФЛЯЦАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГҮҮДИЙН ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, нэгжээр, жил бүрийн 9 дүгээр сард

Бараа, үйлчилгээний бүлэг	2021 IX	2022 IX	Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 9 дүгээр сард улсын хэмжээнд 13.8 хувь гарсны 4.4 (32.0%) нэгж хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.
Ерөнхий индекс	10.2	13.8	
Хүнсний бараа, ундаа, ус	3.9	4.4	
Согтууруулах ундаа, тамхи	0.0	0.1	
Хувцас, бөс бараа, гутал	0.4	2.1	
Орон сууц, ус, цахилгаан, түлш	0.7	1.2	
Гэр ахуйн тавилга, бараа	0.3	0.8	
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.5	1.4	
Тээвэр	3.3	1.6	
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.1	0.1	
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.1	0.2	
Боловсролын үйлчилгээ	0.2	0.3	
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	0.4	0.5	
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	0.0	0.0	
Бусад бараа, үйлчилгээ	0.3	1.0	


ХҮСНЭГТ 3. ИНФЛЯЦАД ИМПОРТЫН БАРААНЫ ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, жил бүрийн 9 дүгээр сард, нэгж хувиар

Үзүүлэлт	2021 IX		2022 IX	
	Нэгж хувь	Хувь	Нэгж хувь	Хувь
Ерөнхий индекс	10.2	100.0	13.8	100.0
Импортын барааны нөлөө	5.6	55.0	7.7	55.5

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 410 нэр төрлийн бараа, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 404 нэр төрлийн бараа, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 410 нэр төрлийн бараа, үйлчилгээний 221 нь импортын бараа байгаа бөгөөд энэ нь нийт жингийн 46.0 хувийг эзэлж байна.

Инфляц 2022 оны 9 дүгээр сард 13.8 нэгж хувь гарсны 7.7 (55.5%) нэгж хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

ЗУРАГ 2. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) сараар, хувиар




Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2021 оны 9 дүгээр сард 15.1 хувиар, 2022 оны 9 дүгээр сард 16.7 хувиар өсөж, өсөлтийн хурдац 1.6 нэгж хувиар, хүнсний бус бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2021 оны 9 дүгээр сард 8.5 хувиар, 2022 оны 9 дүгээр сард 12.7 хувиар өсөж, өсөлтийн хурдац 4.2 нэгж хувиар тус тус нэмэгджээ.

ХҮСНЭГТ 4. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 9 дүгээр сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), бүлгээр, хувь

Огноо	Хүнс, хүнсний бус	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	Ерөнхий индекс	110.2	109.9	110.4	110.7	111.4	110.3
2021 IX	Хүнс	115.1	115.0	114.7	116.2	114.6	115.7
	Хүнсний бус	108.5	108.3	108.8	108.6	110.0	108.2
	Ерөнхий индекс	113.8	114.0	113.9	112.6	114.2	113.1
2022 IX	Хүнс	116.7	117.9	115.3	116.6	114.4	113.1
	Хүнсний бус	112.7	112.7	113.3	111.1	114.2	113.1

Хүнсний бүлгийн үнэ 2022 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотод өмнөх оны мөн үеэс 17.9 хувь, хүнсний бус бүлгийн үнэ Төвийн бүсэд 14.2 хувиар тус тус өссөн нь хамгийн их байна.

ЗУРАГ 3. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 9 дүгээр сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувиар




Барааны бүлгийн үнэ 2021 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 12.2 хувиар, 2022 оны 9 дүгээр сард 15.7 хувиар өсөж, өсөлтийн хурдац 3.5 нэгж хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ 2021 оны 9 дүгээр сард 4.8 хувиар, 2022 оны 9 дүгээр сард 8.3 хувиар өсөж, өсөлтийн хурдац 3.5 нэгж хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 5. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 9 дүгээр сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувь, бүсээр,

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
2021 IX	Ерөнхий индекс	110.2	109.9	110.4	110.7	111.4	110.3
	Бараа	112.2	112.1	112.0	112.3	113.3	112.1
	Үйлчилгээ	104.8	104.7	104.6	105.1	105.6	104.0
2022 IX	Ерөнхий индекс	113.8	114.0	113.9	112.6	114.2	113.1
	Бараа	115.7	115.7	115.6	115.1	117.1	115.0
	Үйлчилгээ	108.3	109.9	107.2	103.7	104.3	105.9

Төвийн бүсэд барааны бүлгийн үнэ 2022 оны 9 дүгээр сард 17.1 хувь, Улаанбаатар хотод үйлчилгээний бүлгийн үнэ 9.9 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 4. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2022 оны 9 дүгээр сард өмнөх сараас 3.3 хувиар буурахад хонь, ямааны махны үнэ 4.3 хувь, үхрийн махны үнэ 3.3 хувь, адууны махны үнэ 4.0 хувь, тахианы махны үнэ дунджаар 1.1 хувиар тус тус буурсан нь, өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар өсөхөд үхрийн махны үнэ дунджаар 2.6 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хот:


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2022 оны 9 дүгээр сард өмнөх сараас 0.3 хувиар буурч, өмнөх оны эцсээс 9.9 хувь, өмнөх оны мөн үеэс 14.0 хувиар өслөө.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 14.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 18.1 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 10.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 20.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 12.8 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 28.9 хувь, тээврийн бүлгийн үнэ 5.2 хувь, боловсролын бүлгийн үнэ 10.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 16.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 9 дүгээр сард өмнөх оны эцсээс 9.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 7.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 5.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 16.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 19.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 22.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 9 дүгээр сард өмнөх сараас 0.3 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 2.5 хувь, тээврийн бүлгийн үнэ 0.5 хувиар буурсан, харин согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 0.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.1 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ЗУРАГ 5. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС сараар (өмнөх оны мөн үеэс), хувиар




Улаанбаатар хотод 2022 оны 9 дүгээр сард хэрэглээний сагсны 404 нэрийн бараа, үйлчилгээний 112 (27.7%) бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас өсөж, 69 (17.1%) бараа, үйлчилгээний үнэ буурч, 223 (55.2%) бараа, үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байна.

ЗУРАГ 6. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЦУЛ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ 2022 оны 9 дүгээр сард 15857 төгрөг болж, 2020 оны 9 дүгээр сараас 21.9 хувь, 2021 оны 9 дүгээр сараас 5.1 хувиар өсөж, өмнөх сараас 474 (2.9%) төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 7. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 9 дүгээр сард 13730 төгрөг болж, 2020 оны 9 дүгээр сараас 22.2 хувь, 2021 оны 9 дүгээр сараас 2.3 хувиар өсөж, өмнөх сараас 506 (3.6%) төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 8. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр



Улаанбаатар хотод худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 9 дүгээр сард 11022 төгрөг болж, 2020 оны 9 дүгээр сараас 20.2 хувиар, 2021 оны 9 дүгээр сараас 0.4 хувиар өсөж, өмнөх сараас 504 (4.4%) төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 9. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ НЭГ ЛИТР АИ-92 БЕНЗИНИЙ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ 2022 оны 9 дүгээр сард 2390 төгрөг болж, 2020 оны 9 дүгээр сараас 70.2 хувь, 2021 оны 9 дүгээр сараас 16.8 хувиар өссөн байна.

Аймаг:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 9 дүгээр сард бүх аймагт өмнөх оны мөн үеэс 10.6-16.3 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 9 дүгээр сард Баянхонгор аймагт 10.6 хувиар өссөн нь хамгийн бага, Завхан аймагт 16.3 хувиар өссөн нь хамгийн их байна.


ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 2022 оны 9 дүгээр сард (өмнөх оны мөн үеэс), хувь, аймаг, нийслэлээр



Аймгуудад худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 9 дүгээр сард 9248 төгрөг болж, 2021 оны 9 дүгээр сараас 458 төгрөгөөр буурсан байна.

Хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 9 дүгээр сард Баянхонгор болон Дундговь аймагт 8000 төгрөг байгаа нь хамгийн бага, Ховд аймагт 11283 төгрөг байгаа нь хамгийн их байна.

ЗУРАГ 11. АЙМГУУДАД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 9 дүгээр сард, төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

Хэрэглээний үнийн индексийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейрсийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – тайлант үеийн хувиргасан Ласпейрсийн индекс (t)

t – тайлант үе

i – бараа, үйлчилгээ

o – суурь үе

P_{it} – i барааны тайлант үеийн үнэ

P_{io} – i барааны суурь үеийн үнэ

Q_{io} – i барааны суурь үеийн жин

Хэрэглээний үнийн индексийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг.

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 404 бараа, үйлчилгээ (аймагт 313 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2018, 2019, 2020 оны дундаж үр дүнгээр жинг тооцон, 2020 оны шинэчилсэн суурьтайгаар 2022 оны 8 дугаар сараас эхлэн тархааж байна.

Хэрэглээний үнийн индексийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан. Мөн аймгийн дундаж үнийг тооцохдоо сонгогдсон 112 сумын үнийн мэдээллийг хамруулж байна.

Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн барааны үнийг сум, аймаг, дүүрэг, нийслэлээс сар бүр цуглуулж байна.



Эх үүсвэр:

ҮСХ, Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээ

Ангилал, код:

Хувийн зориулалттай бараа, үйлчилгээний ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 11 дүгээр сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Д.Батсүх, Х.Хонгорзул
Утас : (976-51)-261559

